



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар A/66

Улаанбаатар хот

Нийслэлийн аварга шалгаруулах
Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнд
оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны A/168 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхэд залууст эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, боловсрол, оюун санаа, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын “Дөл-2024” цогцолбор тэмцээнд ерөнхий боловсролын “Хангай” цогцолбор сургуулийн баг тамирчдыг оролцуулсугай.

2.Нийслэлийн Засаг даргын нэрэмжит тэмцээнд оролцоход шаардагдах төсвийг хавсралтаар баталж, 5,507,000 (Таван сая таван зуун долоон мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Тэмцээнд оролцох баг тамирчдын бэлтгэлийг сайтар хангуулж, зохион байгуулалттай оролцуулан, үр дүнг танилцуулахыг “Хангай” цогцолбор сургуулийн захирал (Э.Соёмбобат), Эрүүл мэндийн төвийн дарга (Х.Ганбат), Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 01 сарын 11-ны өдрийн 1166 дугаар
захирамжийн хавсралт



НИЙСЛЭЛИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭРЭГ-СПОРТЫН
“ДӨЛ” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНД ШААРДАГДАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Шатахуун	л	60	2410	144,600
2.	Газ (7151 унө sonata-7)	л	60	1790	107400
3.	1, 2 дугаар хоол,	5 хоног	15 хүн	25.000	1.875.000
4.	Тактик хувцас	ш	13 хүн	120.000	1.560.000
5.	Хагас түрийтэй гутал	ш	13 хүн	90,000	1,170,000
6.	Нэр-2, лого-2, мөрдөс-1	ш	13 хүн	25,000	325,000
7.	Малгай	ш	13 хүн	25,000	325,000
Дүн					5,507,000